

**А.Д.СИМУКОВ “МОНГОЛЫН ТУХАЙ БОЛОН МОНГОЛД  
ЗОРИУЛСАН БҮТЭЭЛҮҮД” НОМЫН ТУХАЙ***О. Батсайхан\**

А.Д.Симуков “Труды о Монголии и для Монголии” (Монголын тухай болон Монголд зориулсан бүтээлүүд) нэртэй баримт бичиг, бүтээлийн эмхтгэл орос хэл дээр Япон Улсын Осака хот дахь Угсаатаны зүйн музейгээс эрхлэн 2007 оны эхээр хэвлүүлжээ. Монголын түүх, соёл, угсаатан судлал, байгаль орчин судлалд үнэт нэмэр болохуйц эх сурвалжийн чанартай эл бүтээлийг Японы монголч эрдэмтэн Юки Конагая, Монгол Улсын иргэн Санжаасүрэнгийн Баяраа, Ичинхорлоогийн Лхагвасүрэн нар эмхтгэн орос хэл дээр Этнографийн тайлангууд цувралын 66, 67 дугаарт оруулан гурван ботиор хэвлүүлсэн байна. ISBN 1340-6787, ISBN 978 – 4 – 901906-45-6 C3039 гэсэн дугаартай ба [www.minpaku.ac.jp/English/publication/](http://www.minpaku.ac.jp/English/publication/) гэсэн хаягаар орж уг бүтээлийн тухай уншиж болох аж.

А.Д.Симуков “Монголын тухай болон Монголд зориулсан бүтээлүүд” эмхтгэлийн нэгдүгээр ботид Осака хот дахь Угсаатаны зүйн музейгээс эрхлэн Симуковын бүтээлд зориулан зохион байгуулсан олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын материал болон А.Д.Симуковын антроплогийн чиглэлээр бичсэн нэгэн сэдэвт зохиол, угсаатаны зүйн чиглэлээр туурвисан бүтээлүүдийг оруулсан байна. Нэгдүгээр боть 978 хуудастай, түүхэн гэрэл зургуудтай.

Андрей Дмитриевич Симуковын талаар монголчууд өөрийн гэсэн ойлголттой билээ. Юуны түрүүнд түүнийг 1990 онд эхэлсэн Монголын ардчилсан хувьсгалын эцэг Санжаасүрэнгийн Зоригийн өвөө, эдүгээ Улсын Их Хурлын гишүүн Санжаасүрэнгийн Оюуны өвөө гэдгээр өнөөгийн бид сайн мэдэх билээ. Тэгвэл 1990 оны өмнөх үеийнхэн Монголын уран сайханы “Сэрэлт” киноны орос эмчийн дүрд тоглосон орос бүсгүй Доржпаламын эцэг гэдгээр нь мэддэг байв. Энэ талаар өвгөн Дэндэв авгай нэгэнтээ дурсахдаа: “Доржпаламыг үзвэл Дамдинсүрэнг (Симуковыг) үзэх нь тэр” хэмээн хэлээд “А.Д.Симуков туйлын сайхан аясаг зантай, төлөв томоотой, алиа наргиа, явсан газраа хөдөөний ардуудтай маш сайхан эелдэг зөөлөн харилцан, монголчуудын амар мэнд мэдэлцэх ёс журмыг сайн биелүүлдэг байв. Явсан газрын хүнтэй ах дүү нар шиг болдог байлаа. Ялангуяа Архангай, Өвөрхангайн нутагт Симуковыг бараг хүн бүхэн мэднэ. Тэр үед танилцсан Симуковтой ах дүү болсон хүмүүс Монголд маш олон бий. Симуков Монголын зан заншлыг өөрийн биед маш сайн тусган

\* О.Батсайхан - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор (Sc.D), профессор

авсан байлаа. Иймээс үргэлж монгол дээл, эсгий малгайтай явдаг. Түүнийг шар Дамдинсүрэн гэнэ” хэмээн түүний тухай өгүүлсэн буй. Үнэхээр хорьдугаар зууны дунд үеийн хүмүүс, орон нутгийн зон олон түүнийг Шар Дамдинсүрэн хэмээн авгайлан дууддаг нэрээр нь андахгүй мэддэг төдийгүй, түүнд ам сайтай явж ирсэний зах зухаас өчүүхэн хүн сонсож байсан билээ.

Харин Судар бичгийн хүрээлэнгийнхэн эдүгээгийн Шинжлэх ухааны академийнхан, түүний дотор түүх, газар зүй, угсаатан судлалын эрдэмтэд түүнийг бүр илүүтэй эрдэм судлалын ажлаар нь таньж мэддэг билээ.

Тиймээс Монголд хорин нэгхэн настай ирж, амьдралынхаа алтан үеийг Монголд өнгөрүүлсэн түүний бүтээлүүдийг хэвлэгдэн гарч буйд эрдэм судлалын бид төдийгүй нийт монголчууд, дэлхийн монголч судлаачид талархан угтаж буй гэдэгт өчүүхэн ч эргэлзэхгүй байна.

А.Д.Симуков 40 жил амьдрахдаа 21 настайдаа анх Монголд хөл тавьж, 16 жил Монголд амьдарч, ажиллажээ. Тэрбээр анх Монголд 1923 онд ирсэн П.К.Козловын экспедицийн бүрэлдэхүүнд ирж, 1927 оноос 1939 онд Монголын Шинжлэх ухааны хүрээлэнд эрдэм шинжилгээний ажилтнаар ажиллаж байжээ. Тэрбээр 15 эспедици, аялалд зохион байгуулагч, удирдагч, ажилтанаар оролцож, Монголын бараг бүхий л нутгаар аялсан байна. Симуковын судалгааны гол чиглэл нь газар зүй, мал аж ахуй, малын бэлчээр, засаг захиргааны бүтэц зохион байгуулалт байжээ. Тэрбээр Монголын талаар олон жилийн турш хийсэн судалгааныхаа үр дүнг “БНМАУ-ын газар зүйн атлас” (1934 онд Улаанбаатар хотноо монгол, орос хэл дээр хэвлэгдсэн), “БНМАУ-ын ерөнхий карт” (Улаанбаатар, 1937), “Современная Монголия”, “Хозяйство Монголии” зэрэг сэтгүүлд хэвлүүлсэн 30 гаруй өгүүлэлдээ тусгасан байна.

Түүнийг баривчилсаны улмаас хэвлэхээр бэлтгэж байсан зарим бүтээлүүд нь нийтлэгдээгүй бөгөөд олны сонорт хүрээгүй байсаар эдүгээ хүрчээ.

Харин азаар Монгол Улсын Шинжлэх ухааны хүрээлэнгийн гар бичмэлийн санд орж, эдүгээ Монгол Улсын ШУА-ийн Газар зүйн хүрээлэн, Үндэсний төв архивт хадгалагдаж байгаа Симуковын бүтээлүүдийг одоогийн эмхтгэлд багтааж, эрдэм шинжилгээний эргэлтэд оруулж буй нь тун сайшаалтай болжээ.

Эмхэтгэгчдийн бичсэнээр Монгол Улсын архиваас олдсон Симуковын орос хэл дээрх бүх бүтээлүүдийг эл эмхтгэлд багтаасан байна.

А.Д.Симуков “Труды о Монголии и для Монголии” Монголын тухай болон Монголд зориулсан бүтээлүүд нэртэй баримт бичгийн эмхтгэлийн нэгдүгээр ботид Монголын газар зүйн холбогдолтой зохиол бүтээлийг нь ихэвчлэн хамруулсан байна. Тухайлбал, “БНМАУ-ын газар зүйн түүхэн найруулал” хэмээх 25 хэвлэлийн хуудастай томоохон

судалгааны суурь бүтээл орсон бөгөөд эл бүтээл нь А.Д.Симуковын материалын үндсэн дээр бүтсэн бөгөөд ХХ зууны 30-аад оны Монголын хүн ам, байгаль орчин, аж ахуйн тухай бүрэн хэмжээний мэдлэг олгохуйц хэмжээний мэдээллийг багтаасан байна. Энэхүү суурь бүтээлийн нэгдүгээр хэсэгт Монголын физик газар зүйн дэлгэрэнгүй тодорхойлолтыг хийж, түүний дагуу шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тус орны засаг захиргааны хуваарийг тогтоохыг оролдсон байна. Харин эл бүтээлийн хоёрдугаар хэсэг нь Монголын хүн ам, түүний аж ахуй, ажил хөдөлмөр эрхлэлт, соёл, шашины тухай тодорхой мэдээллийг багтаасан байна. Мөн нүүдлийн мал аж ахуйн талаар маш тодорхой шинжилгээ хийсэн байна.

Монголын түүх, сүм хийдийн үйл ажиллагаа, лам нарын асуудал хийгээд БНМАУ-ын төрийн зохион байгуулалт, худалдаа, үйлдвэр, тээвэр, холбооны асуудлуудыг тус тусад нь зүйлүүдэд тусгасан байна. Мөн томоохон суурин газрууд, сүм хийдүүд, зам харилцааны газруудын нэрсийг тодорхой жагсаан харуулсан байна.

Уг бүтээлийн гуравдугаар хэсэгт аймаг тус бүрийн эдийн засаг, газар зүй, угсаатан ястаны байдал зэргийг иж бүрнээр нь тодорхой дүрслэн харуулжээ. Эл хэсэгт улс орныг эдийн засгийн бүс нутгуудад хуваах саналыг анх удаа гаргаж тавьжээ.

Энэхүү суурь бүтээлийг А.Д.Симуков хураангуйлан “БНМАУ-ын товч газар зүй” хэмээх нэртэй газар зүйн сурах бичиг бичсэнийг мөн эмхтгэлд багтаажээ. Дээр дурьдсан суурь бүтээл хийгээд түүний хураангуй хоёул орос хэл дээр бичигдсэн ба тэдгээрийг монгол хэл дээр зохиогч өөрөө хөрвүүлж байжээ.

А.Д.Симуковын говийн газар зүйн шинж төлвийг анх удаа тодорхойлсон, говийн түүхэн хөгжил, хавтгай зэрэг говь нутгийн ан амьтдын талаарх мэдээллийг багтаасан “Баруун говь”, тус бүс нутгийн газар зүйн онцлог, ойн тогтоц, ангийн аж ахуй эрхэлж ирсэн байдал зэргийг агуулсан “Хэнтийн баруун өмнө зүгээр хийсэн аяллын тайлан 1924-1925 оны өвөл” зэрэг газар зүй судлалын чиглэлээр туурвисан бүтээлүүдийг эл эмхтгэлд оруулсан нь газар зүй, байгаль орчин судлаачдад тун олзуурхууштай эх сурвалж болох буй за.

Баримт бичгийн эмхтгэлийн хоёрдугаар ботид Монголын хүн амын ахуй байдал, соёл, нүүдлийн мал аж ахуй, бэлчээрийн асуудлуудыг илүү тусгасан А.Д.Симуковын бүтээлүүд оржээ.

Урьд өмнө хэвлэгдээгүй зохиогчийн бүтээлүүдээс томоохонд орох зохиол бол “БНМАУ-ын говийн бэлчээр” хэмээх нэртэй 10 хэвлэлийн хуудас бүхий нэгэн сэдэвт зохиол ажээ. Энэхүү бүтээлд Монголын говийн бэлчээрийн ангиллыг анх удаа хийж, бэлчээрийн тэжээллэг байдал, аж ахуйн ач холбогдолыг тодорхойлж, говийн нутагт мал аж ахуй эрхлэхийн онцлог, говьд тохиолддог ган гачгийн давтамжийн

байдал, түүнийг хэрхэн даван туулах талаарх зарим зөвлөмжийг агуулсан эл бүтээлийг эмхтгэлд багтаасан нь энэ чиглэлийн судалгаа, шинжилгээ хийж буй эрдэмтэн, багш, судлаач, оюутнуудад онц сонирхолтой төдийгүй судалгааны эх сурвалж болохуйц байдлаараа онцгой ач холбогдол агуулж байна.

А.Д.Симуковын дээр дурьдсан зохиолд Монголын говь нутгийн байдлын талаар өгүүлсэн бол түүний “Төв болон дорнод Хангайн бэлчээр” бүтээлд 1930-аад оны Монголын хангайн бүс нутгийн бэлчээрийн байдлыг тодорхой дүрслэн харуулжээ. Мөн В.И.Баранов лугаа хамтран хийсэн “БНМАУ-ын нутаг дэвсгэр дэх ургамлын цогц байдлыг харуулсан газрын зураг”-ийг оруулсан байна.

Эл эмхтгэлийн хоёрдугаар ботид 1920-1930 аад онд нийтлэгдсэн, Монголын нүүдэлчдийн шинж байдал, тэдгээрийн үүсэл, хөгжил, байгаль, нийгмийн нөхцөлтэйгээ уялдаж ирсэн байдал, мал аж ахуй эрхлэх өвөрмөц аргуудыг тодорхой харуулсан А.Д.Симуковын өгүүллүүд оржээ.

Эмхтгэлийн гутгаар ботид А.Д.Симуковын 1927 оноос 1938 онуудад хийсэн экспедицийн хөтөлбөр, тайлан, замын болон өдрийн тэмдэглэл зэргийг оруулсан нь судлаач, мэргэжилтнүүдийн сонирхолыг татахуйц баримт бичиг, мэдээллүүдийг агуулсан байна.

Эл ботид А.Д.Симуковын идэвхтэй оролцоотой, шинжлэх ухааны үндэслэлтэйгээр боловсруулан хийгдсэн Монголын засаг захиргааны шинэ хуваарийг бүсчилэх талаарх судалгааны үр дүн болсон “Өмнөговь аймгийн шинэ төвийг сонгох тухай БНМАУ-ын Эдийн засгийн зөвлөлд оруулсан тайлан”, “БНМАУ-ын хөдөө аж ахуй, эдийн засгийн бүсчилэл” зэрэг зохиолуудыг багтаасан байна.

А.Д.Симуковын “1931 оны БНМАУ-ын хүн амын тооллогын тухай тэмдэглэл”, “Улаанбаатар орчмын ой модыг ашиглах тухай тэмдэглэл”, “Монголын усан тээврийн боломжийн тухай”, “Хангайн дорнод хэсгийн халуун эх сурвалжууд” зэрэг төрөл бүрийн чиглэлээр бичсэн материалуудыг бас багтаасан байна.

Ийнхүү саяхан болтол мартагдсан мэт байсан, нэрт эрдэмтэн А.Д.Симуковын бараг төлөв бүх бүтээлүүдийг иж бүрнээр анх удаа хэвлэн нийтэлж, эрдэм шинжилгээний эргэлтэнд оруулсан нь Монголын түүх, соёл, газар зүй, байгал орчин судлалын хөгжилд түлхэц болохоор сайн үйлс болжээ хэмээн бодож байна.

Энэхүү сайн үйлсийг бүтээх анхны шавыг 1990 оны 9 дүгээр сарын 25-нд Монгол Улсын ШУА-ийн Ерөнхийлөгч Н.Содном А.Д.Симуковын эрдмийн өвийг судлах комисс байгуулах шийдвэрээрээ тавьж байсан ажээ. Эл комиссын бүрэлдэхүүнд А.Д.Симуковын охин Н.А.Симукова, ач Санжаасүрэнгийн Баяраа нар орж ажилласаар

энэхүү гурван боть баримт бичгийн эмхтгэл томоохон бүтээл хэвлэгдэн гарахад дөхмийг үзүүлжээ.

Эрдэмтэний маань охин Н.А.Симукова цуцалтгүй их зүтгэл гаргаж, аавынхаа бүтээлүүдийг Монголын болон Оросын архив, номын сангуудаас эрэл хийж олж авсанаа эмхтгэгчдэд өгсөн нь энэхүү бүтээлийг улам баяжуулсан байна.

Монголын шинжлэх ухааны хөгжилд томоохон байр эзлэх нэрт эрдэмтэн А.Д.Симуковын бүтээлүүдийг эрдэм шинжилгээний эргэлтэнд оруулж, Монголын төдийгүй дэлхийн эрдэмтэн судлаачдын хүртээл болгоход Японы монголч эрдэмтэн, Осака дахь Угсаатан судлалын музейн ахлах ажилтан Юки Конагая ихээхэн хувь нэмрээ оруулсан байна.

А.Д.Симуковын 2000 гаруй хуудастай бүтээлүүдийг гурван ботиор хэвлүүлж, 1934 оны “БНМАУ-ын газар зүйн атлас”, 1937 оны “БНМАУ-ын газрын зураг”-ийг компакт дискэнд оруулж хавсаргасан байна.

XX зууны хорь, гучаад оны үеийн Монголын түүхийн олон ээдрээтэй асуудлуудыг тодруулахад дөхөм болохуйц, түүх, газар зүй, байгаль орчин судлалын олон асуудлыг шинээр судлахад эх сурвалжийн чанартай баялаг материал агуулсан, нэрт монгол судлаач эрдэмтэн, Монголд зүрх сэтгэлээ нэвт шингээсэн А.Д.Симуковын бүтээлийн эмхтгэл Япон улсад орос хэл дээр хэвлэгдэн гарсан нь монгол судлал хийгээд газар зүй, байгаль орчин судлалын эрдэмтэн мэргэд, сэхээтэн, Монголын түүх, соёл сонирхогч хэн бүхний таашаалд нийцсэн, үр өгөөжтэй ажил болжээ хэмээн үзэж байна.

